



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/91/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Булган аймаг
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: **7034-2580**

Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: **7034-2716**

Цахим хаяг: : enkhtsoodolj@audit.gov.mn

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид

Утас: **9511-2689**

Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Аудитор Ш.Ганчимэг

Утас: **99377360**

Цахим хаяг: shagdarganchimeg44@jmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13-14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	14-16
4. Аудитын тайлан.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17-18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт	19-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20-21
7. Асуудлын бүртгэл.....	22
7.1. Төлбөрийн акт, албан шаардлага	23-32

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ЕБС	Ерөнхий боловсролын сүргүүл

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.08.24 № 213
танай _____ ны № _____ т

БЯАН-АГТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Агт сумын ЕБС-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баян-Агт сумын ЕБС-ийн 2022 оны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс 1,119,966.4 мянга, орон нутгийн төсвөөс 340,509.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас нийт зардлын гүйцэтгэл 99.5 хувьтай хэрэгжжээ.

Тайлант онд БШУС-ын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/452 дугаар тушаалаар хуваарилсан 37,465.0 мянган төгрөгөөр төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс гэрээний дагуу компьютер, тоног төхөөрөмж худалдан авч санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Тус сургуулийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

D:/bichighereg/2023A4toot

006020238

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын даргын 2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 7 зорилтын хүрээнд 46 арга хэмжээ баталснаас гүйцэтгэлээр 91.8 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>108,554,816.78</u>	<u>94,192,858.53</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,080,073.46
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	1,080,073.46
33	АВЛАГА	13,000,000.00	3,162,287.29
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	2,762,287.29
335	Бусад авлага	13,000,000.00	400,000.00
3351	Байгууллагаас авах авлага	13,000,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	400,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	95,554,816.78	89,950,497.78
351	Түүхий эд материал	175,000.00	315,644.00
35110	Тусгай зориулалттай материал	-	140,644.00
35130	Эм боох материал	175,000.00	175,000.00
354	Хангамжийн материал	95,379,816.78	89,634,853.78
35410	Бичиг хэргийн материал	3,850,600.00	5,397,000.00
35420	Аж ахуйн материал	90,204,122.98	79,604,014.98
35460	Хүнсний материал	989,919.80	1,800,464.80
35470	Бусад хангамжийн материал	335,174.00	2,833,374.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,584,532,249.72</u>	<u>1,584,820,311.26</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,584,532,249.72	1,584,820,311.26
392	Биет хөрөнгө	1,543,989,749.72	1,544,615,311.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,528,011,910.00	1,528,011,910.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(138,142,603.97)	(186,055,150.73)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	113,254,421.64	177,699,220.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(62,989,367.78)	(78,484,199.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	125,080,105.71	142,171,936.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	(49,654,048.45)	(64,157,294.96)
39217	Ном	28,429,332.57	25,428,889.97
393	Биет бус хөрөнгө	40,542,500.00	40,205,000.00
39301	Програм хангамж	1,750,000.00	1,750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(737,500.00)	(1,075,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	39,530,000.00	39,530,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,693,087,066.50</u>	<u>1,679,013,169.79</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>14,574,769.79</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	14,574,769.79
413	Өглөг	-	14,574,769.79

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,762,287.29
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	11,812,482.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,693,087,066.50	1,664,438,400.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1,693,087,066.50	796,350,796.72
511	Засгийн газрын оруулсан капитал	796,350,796.72	
512	Хуримтлагдсан үр дүн	(242,698,379.06)	271,347,045.56
51210	Өмнөх үеийн үр дүн	(242,698,379.06)	(242,698,379.06)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(28,648,666.50)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,139,434,648.84	1,139,434,648.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,693,087,066.50	1,679,013,169.79

“ЦЭСБ аудит” ХХК

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,289,530,447.48	1,506,270,490.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	55,664,449.48	43,244,890.40
120	Нийтлэг татварын бус орлого	990,000.00	43,244,890.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	990,000.00	1,512,610.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	990,000.00	-
120005	Түрээсийн орлого	-	2,035,000.00
120009	Бусад орлого	-	2,550,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	43,895,399.48	33,802,636.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	10,779,050.00	5,894,644.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,233,865,998.00	1,460,475,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	950,598,300.00	1,119,966,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,119,966,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	950,598,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,188,898.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	682,778.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,506,120.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	280,078,800.00	340,509,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	280,078,800.00	340,509,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,296,260,004.34	1,531,489,346.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,296,260,004.34	1,531,489,346.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,259,907,487.54	1,476,572,353.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	735,924,147.00	849,705,088.54
210101	Үндсэн цалин	499,414,138.80	631,050,065.54

210102	Нэмэгдэл	179,891,690.00	178,420,850.00
210104	Урамшуулал	56,618,318.20	40,234,173.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,427,721.00	106,616,251.00
210201	Тэтгэврийн даатгал	66,392,196.00	72,529,485.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,262,886.00	8,532,804.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,583,003.00	6,826,303.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,274,414.00	1,738,542.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,915,222.00	16,989,117.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	278,501,540.00	290,758,412.50
210301	Гэрэл, цахилгаан	4,355,328.00	6,275,000.00
210302	Түлш, халаалт	273,896,212.00	284,293,412.50
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	190,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,850,952.00	-
210401	Бичиг хэрэг	2,052,178.00	-
210402	Тээвэр, шатахуун	1,614,100.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	532,000.00	-
210404	Ном, хэвлэл	3,900.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	899,300.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,749,474.00	-
2105	Нормативт зардал	44,882,230.00	85,501,725.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,519,650.00	-
210502	Хоол, хүнс	40,257,450.00	85,501,725.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,105,130.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,312,100.00	1,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,000.00	-
210602	Тавилга	133,100.00	-
210604	Урсгал засвар	1,129,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	401,200.00	-
210702	Дотоод албан томилолт	401,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,131,619.00	7,618,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,131,619.00	2,035,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,583,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,475,978.54	135,372,676.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,468,813.19	42,585,012.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,854,300.00	11,318,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,152,865.35	81,469,264.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,352,516.80	54,916,993.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,770,700.00	48,804,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,220,700.00	48,804,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	550,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,581,816.80	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,581,816.80	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	6,112,993.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,112,993.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(6,729,556.86)	(25,218,855.85)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	3,429,810.65
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,429,810.65
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(3,429,810.65)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(6,729,556.86)	(28,648,666.50)

“ЦЭСБ аудит” ХХК

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,235,474,548.00	1,466,573,210.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	6,097,610.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	6,097,610.00
12004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,608,550.00	1,512,610.00
120005	Түрээсийн орлого	-	2,035,000.00
120009	Бусад орлого	-	2,550,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,233,865,998.00	1,460,475,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	950,598,300.00	1,119,966,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,119,966,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	950,598,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,188,898.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	682,778.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,506,120.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	280,078,800.00	340,509,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	280,078,800.00	340,509,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,225,417,748.00	1,427,108,636.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,225,417,748.00	1,427,108,636.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,189,907,607.20	1,362,811,443.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	736,610,138.20	850,105,088.54
210101	Үндсэн цалин	500,100,130.00	631,450,065.54
210102	Нэмэгдэл	179,891,690.00	178,420,850.00
210104	Урамшуулал	56,618,318.20	40,234,173.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,427,721.00	106,616,251.00
210201	Тэтгэврийн даатгал	66,238,410.00	72,529,485.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,059,600.00	8,532,804.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,786,289.00	6,826,303.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,428,200.00	1,738,542.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,915,222.00	16,989,117.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	278,501,540.00	280,268,800.00

210301	Гэрэл, цахилгаан	4,355,328.00	5,930,000.00
210302	Түлш, халаалт	273,896,212.00	274,148,800.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	190,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,969,978.00	-
210401	Бичиг хэрэг	643,978.00	-
210402	Тээвэр, шатахуун	1,753,200.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	532,000.00	-
210404	Ном, хэвлэл	186,600.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,575,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,279,000.00	-
2105	Нормативт зардал	43,279,410.00	78,382,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	596,200.00	-
210502	Хоол, хүнс	40,878,110.00	78,382,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,805,100.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,180,900.00	1,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,050,000.00	-
210602	Тавилга	133,100.00	-
210604	Урсгал засвар	997,800.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	401,200.00	-
210702	Дотоод албан томилолт	401,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,200.00	9,863,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,200.00	2,035,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	7,828,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,376,520.00	36,575,304.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,187,120.00	25,149,904.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,189,400.00	11,425,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,510,140.80	64,297,193.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,928,324.00	58,184,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,378,324.00	58,184,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	550,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,581,816.80	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,581,816.80	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	6,112,993.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,112,993.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,056,800.00	39,464,573.46
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,056,800.00	38,384,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,056,800.00	38,384,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,056,800.00	38,384,500.00
222001	Тоног төхөөрөмж	6,989,900.00	38,072,000.00
223001	Бусад хөрөнгө	3,066,900.00	312,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(10,056,800.00)	(38,384,500.00)

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	1,080,073.46
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,080,073.46

“ЦЭСБ аудит” ХХК

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	(242,698,379.06)		1,693,087,066.50
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	(242,698,379.06)	-	1,693,087,066.50
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(41,767,132.28)		(41,767,132.28)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	(284,465,511.34)	-	1,651,319,934.22
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	(284,465,511.34)	-	1,651,319,934.22
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	(284,465,511.34)	-	1,651,319,934.22
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(95,071,766.50)		(95,071,766.50)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	(379,537,277.84)	-	1,556,248,167.72

“ЦЭСБ аудит” ХХК

2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,461,433,700.00	1,465,493,136.54	(4,059,436.54)	100.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,461,433,700.00	1,427,108,636.54	34,325,063.46	97.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,403,249,500.00	1,362,811,443.54	40,438,056.46	97.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	850,864,900.00	850,105,088.54	759,811.46	99.91
210101	Үндсэн цалин	651,031,800.00	631,450,065.54	19,581,734.46	96.99
210102	Нэмэгдэл	179,017,700.00	178,420,850.00	596,850.00	99.67
210104	Урамшуулал	20,815,400.00	40,234,173.00	(19,418,773.00)	193.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,637,400.00	106,616,251.00	21,149.00	99.98
210201	Тэтгэврийн даатгал	72,529,500.00	72,529,485.00	15.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,532,800.00	8,532,804.00	(4.00)	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,826,300.00	6,826,303.00	(3.00)	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,704,500.00	1,738,542.00	(34,042.00)	102.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,044,300.00	16,989,117.00	55,183.00	99.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	280,278,800.00	280,268,800.00	10,000.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	5,930,000.00	5,930,000.00	-	100.00
210302	Түлш, халаалт	274,148,800.00	274,148,800.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	190,000.00	10,000.00	95.00
2105	Нормативт зардал	78,382,400.00	78,382,400.00	-	100.00
210502	Хоол, хүнс	78,382,400.00	78,382,400.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,863,600.00	9,863,600.00	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,035,000.00	2,035,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,828,600.00	7,828,600.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,222,400.00	36,575,304.00	39,647,096.00	47.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,479,500.00	25,149,904.00	39,329,596.00	39.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,742,900.00	11,425,400.00	317,500.00	97.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,184,200.00	64,297,193.00	(6,112,993.00)	110.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,184,200.00	64,297,193.00	(6,112,993.00)	110.51
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,184,200.00	58,184,200.00	-	100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох		6,112,993.00		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэн		6,112,993.00		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	38,384,500.00	(38,384,500.00)	

2200	Дотоод эх үүсвэрээр	-	38,384,500.00	(38,384,500.00)	
222001	Тоног төхөөрөмж	-	38,072,000.00	(38,072,000.00)	
223001	Бусад хөрөнгө	-	312,500.00	(312,500.00)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,461,988,210.00	1,394,052,500.00	67,935,710.00	95.35
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,119,966,400.00	1,053,543,300.00	66,423,100.00	94.07
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,119,966,400.00	1,053,543,300.00	66,423,100.00	94.07
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	340,509,200.00	340,509,200.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	340,509,200.00	340,509,200.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,512,610.00	-	1,512,610.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,512,610.00	-	1,512,610.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,080,073.46	(1,080,073.46)	

“ЦЭСБ айдум” ХХК

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургууль нь сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм. Тайлант онд "Сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж ээлжит хичээлийн чанар үр өгөөжийг нэмэгдүүлж, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, сургуулийн өнөөгийн хүрсэн түвшинг хадгалж, ахиулах" гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Салбарын бодлого, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ерөнхий боловсролын сургуулийн хөгжлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ,
- Бага дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын арга зүй, технологийг хөгжүүлэх,
- Байгууллагын хүний нөөцийн хөгжил, төлөвшлийг хангах, багшийн хөгжлийг дэмжих,
- Байгууллагын санхүүгийн болон материаллаг нөөцийг төлөвлөх, хэрэгжүүлэх, суралцагч, багш ажилтныг эрүүл, аюулгүй таатай орчинд сурч төлөвших, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай" журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан "Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай" тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох" тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,

- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлсон тул гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 захирамжаар баталсан Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тус сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,073.9 мянган төгрөгөөр буюу 0.83 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	1,080.1	1,080.1
Авлага	13,000.0	3,162.3	(9,837.7)
Байгууллагаас авах авлага	-	-	-
Бараа материал	95,554.8	89,950.5	(5,604.3)
Үндсэн хөрөнгө	1,584,532.3	1,584,820.3	288.0
Үндсэн хөрөнгийн элэгдэл			
Нийт хөрөнгө	<u>1,693,087.1</u>	<u>1,679,013.2</u>	<u>(14,073.9)</u>
Өр төлбөр		14,574.8	14,574.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,693,087.1	1,664,438.4	(28,648.7)

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>1,693,087.1</u>	<u>1,679,013.2</u>	<u>(14,073.9)</u>
---	---------------------------	---------------------------	--------------------------

Өмнөх оны авлагад бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас 13,000.0 мянган төгрөгийн ухаалаг самбар хүлээн авч, бүрэн барагдуулсан байна.

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 1,080.1 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ.” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 89,950.5 мянган төгрөг болж 5,604.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны аж ахуйн материалын зарцуулалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,584,820,3 мянган төгрөг болж 288.0 мянган төгрөгөөр өсчээ. БШУС-ын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/452 дугаар тушаалаар техник, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардалд хуваарилсан 37,465.0 мянган төгрөгөөр төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс компьютер, тоног төхөөрөмж худалдан авсан, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 12,309.2 мянган төгрөгийн гал зуухны тоног төхөөрөмж, 18,2134 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 312.5 мянган төгрөгийн ном, сурах бичиг, төгсөгчдийн хандиваар 16,280.0 мянган төгрөгийн цахилгаан хөгжим /иж бүрдэл/, 1,000.0 мянган төгрөгийн 5 ширхэг телевизор зэрэг хөрөнгийг хүлээн авчээ.

Тайлант хугацаанд 81,469.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, 6,651.0 мянган төгрөгийн хөрөнгө акталсан нь үндсэн хөрөнгө буурахад нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,664,438.4 мянган төгрөг болж 28,648.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой.

3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны төсвийн нийт зарлагыг 1,461,433.7 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,119,966.4 мянга, орон нутгийн төсвөөс 340,509.2 мянга, төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоос 1,512.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,119,966.4 мянган төгрөгийг баталж, орон нутгийн төсвөөс 340,509.2 мянган

төгрөгийн санхүүжилт хуваарилж, төсөвт байгууллагын үйл ажиллагааснаас 1,512.6 мянган төгрөг оруулжээ,

Гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, 1,080.1 мянган төгрөг зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнасан байна. Нийт зардлын 65.2 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 19.2 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эзэлж байгаа бол дотуур байрны хоол, хүнс, үдийн хоолны зардал 9.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
71802 Ерөнхий боловсрол	1	81801- Үдийн цай хөтөлбөр	58,184.2	58,184.2	-	100
	2	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	281,279.0	281,268.8	10.2	
	3	80112- Нийтлэг үйлчилгээ	53,127.5	53,127.5		100
	4	80226- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,131.5	2,857.7	273.8	91.26
	5	80312- Сургалт семинар	1,565.7	1,565.7		100
	6	81605- Эрүүл мэндийг дэмжих	3,601.2	3,601.2		100
	7	81806-Дотуур байрны хүүхдийн хоол	95,324.3	90,726.0	4,598.3	
	9	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин				
	10	81823- Боловсролын багшийн сургалт	7,045.8	7,045.8		100
	11	81834- Боловсролын стандарт сургалт	786,059.5	785,916.6	143.2	
	12	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	127,589.1	126,951.1	638.0	
	13	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	37,465.0	37,465.0		100
	14	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	2,476.0	203.3	2,272.7	
	15	83603-Нэмэлт дээд шатны төсвөөс	3,550.0	3,843.3	-1,284.3	
	16	80102-Туслах үйл ажиллагааны зардал		1,284.3	-1,284.3	
	Нийт					1,080.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн орлого байхгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах тухай өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Б.Гантуяа нар гүйцэтгэж, хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Агт сумын ЕБС 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,461,433.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 14,614.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төрийн хэмнэлтийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан байна. Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ, бараа үйлчилгээний бусад зардлаас 1,080.1 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд боловсролын байгууллагын мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	4,994.3	1	4,994.3	100
Зөвлөмж	3	228.0	3	228.0	100
Нийт дүн	4	5,222.3	4	5,222.3	100

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 24-ний 1/23 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бараа, материалын зарцуулалтыг анхаарах асуудалд оруулах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15,491.1 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илэрснээс аудитын явцад 3,719.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,285.9 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт, 7,284.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 3,202.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Сургуулийн захирлын 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/26 дугаар тушаалаар нэр бүхий багш нарт ур чадварын нэмэгдлийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн 472.3 мянган төгрөгөөр илүү олгосон зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д *“Анхан шатны баримтын үнэн, зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”*, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны А/35А/10/1 дугаар хамтарсан тушаалын хавсралт *“Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим ажилтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”-ийн 10-т “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60 ба түүнээс дээш үнэлэгдсэн багш ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараахь хувиараар олгоно.” /10-25 хувь/ гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.*

2. Тус сургуулийн дотуур байрны тогтооч М.Лхагвасүрэнд сахилгын шийтгэлтэй байх хугацаанд 256.6 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д *“Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно”*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын хавсралтын 4.3-т *“Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ...ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3. Тус сургуульд нягтлан бодогчоор ажиллаж байсан Б.Оюун-Эрдэнэд захирлын тушаалаар үндсэн цалингийн 60 хувиар буюу 454,600.0 төгрөгийн шагнал олгосон нь улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал, ур чадварын нэмэгдэлтэй давхардсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д *“анхан шатны баримтын үнэн зөвийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т *“Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал урамшуулал, дэмжлэг олгох”*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын хавсралтын 4-т *“Мөнгөн урамшуулал олгоход дараахь шалгуур үзүүлэлтийг баримтална”* гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

4. Тус сургуулийн 2022 оны 6 дугаар сарын няравын тайланд 102,400.0 төгрөгийн Аи 92 шатахууныг үндэслэх баримтгүйгээр зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д *“Анхан шатны баримтын үнэн, зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”*, 13 дугаар зүйлийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

5.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд олгосон үр дүнгийн мөнгөн урамшууллыг шалгахад 12 дугаар сард ажилтнуудын ажлыг дүгнэхгүйгээр хавтгайруулан 7,284,000.0 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтын 4.3-т “Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно”, 4.5-д “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно” гэсэн заалттай заалттай нийцэхгүй тул албан шаардлага өглөө.

5.3 Зөвлөмж

Хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт

Тайлант оны 4, 6 дугаар сард зарцуулсан 3,202.3 мянган төгрөгийн шатахууны тооцоог бодоогүй, зөвхөн няравын тайлангийн зарцуулалтын дүнгээр зардалд бичсэн, жолоочийн замын болон дагалдах хуудсыг баталгаажуулж тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж

Шатахууныг жолоочийн баталгаажуулсан замын хуудас, тооцооны дагалдах баримтыг үндэслэн тооцоог бодож, зарцуулсан дүнгээр зардалд бичих, дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өглөө.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

5.1 Зөвлөмж

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн Тоо	Үүнээс					Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн		Залруулсан		Залруулаагүй			Тоо	Дүн
						Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Сумын ЗДТГ-с шилжүүлсэн камер дагалдах хэрэгслэлийг бүртгээгүй.	1	3,280.0	1	3,280.0		1	3,280.0					

